

## АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

**Байршил:** Налайх дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс  
**Эхлэх хугацаа:** 2024/11/18 **Дуусах хугацаа:** 2024/11/30  
**Ажил эхлэх хугацаа:** 2024/12 **Цалин:** Боловсрол, ажлын туршлагыг харгалзана.

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2013 онд байгуулагдсан Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль нь Монгол Улсын төрийн өмчит дээд боловсролын байгууллага юм. Тус сургууль нь Монгол Улсын болон ХБНГУ-ын Засгийн газрын дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

## ОЮУТНЫ БАЙРНЫ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

### *Гүйцэтгэх үндсэн чиг үүрэг:*

- Оюутны байранд амьдарч буй оюутнуудтай ганцаарчлан болон бүлгээр уулзалт хийж, санал хүсэлтийг нь сонсож ажиллах;
- Оюутны байранд гарч болох асуудлууд болох өрөөний хүүхэдтэйгээ зөрчилдөх, хувийн, сэтгэл зүйн болон бусад асуудлуудад анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх;
- Оюутны байрны үйл ажиллагааг хэвийн, эмх цэгцтэй байлгахын тулд дүрэм, журмыг мөрдүүлэх, үүдэн гарах үр дагавраас сэрэмжлүүлэх;
- Шаардлагатай үед эмнэлгийн яаралтай анхны тусламж үзүүлэх;
- Ээлжинд гарч ажиллах.

### *Тавигдах шаардлага:*

- Сэтгэл судлал, нийгмийн ажилтан, боловсрол судлалын чиглэлээр бакалаврын зэрэгтэй байх;
- Их, дээд сургууль, коллежид багш, зохион байгуулагчаар ажиллаж байсан бол давуу тал болно;
- Харилцааны соёлтой, бие даан ажиллах чадвартай байх;
- Оюутнуудад чиглэсэн үйлчилгээг үзүүлж чаддаг байх;
- Оффисын хэрэглээний программууд дээр чөлөөтэй ажиллах чадвартай байх;
- Англи хэлний мэдлэгтэй бол давуу тал болно.

### *Бүрдүүлэх материал:*

- Ажилд орох өргөдөл
- Товч намтар
- Мэргэжлийн ур чадварыг тодорхойлсон диплом, сертификат болон батламжийн хуулбар
- Өмнөх ажил олгогчийн тодорхойлох захиа

### *Холбоо барих:*

Та баримт бичгээ монгол хэл дээр бэлтгэн 1 PDF файл болгон эмхэтгэж [recruitment@gmit.edu.mn](mailto:recruitment@gmit.edu.mn) хаягаар бидэнд ирүүлнэ үү.

**Цахим хуудас:** [www.gmit.edu.mn](http://www.gmit.edu.mn)

Бидэнтэй +976 7023-2090 тоот утсаар болон цахим хаягаар холбогдох боломжтой.

**Жич:** *Зөвхөн шаардлага хангасан ажил горилогчидтой эргэн холбогдож ажлын ярилцлагад урих болно.*